



“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЭГШ БАЙДЛЫН МАНЛАЙЛАГЧИД” ТӨСЛИЙН УРАЛДААН

Жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг Дэлхийн эрүүл мэндийн өдөр (ДЭМӨ)-ийг 2021 онд “Хүн бүрт илүү тэгш, эрүүл ертөнцийг бий болгохын төлөө” уриан дор зохион байгуулж байна.

“Арьс өнгө, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлаасаа үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг байж болох хамгийн дээд стандартын түвшинд хүртэх боломжтой байх нь хүн бүрийн үндсэн эрхүүдийн нэг юм” гэсэн нь ДЭМБ-ын үзэл баримтлалын суурь зарчим болно.

Дэлхийн эрүүл мэндийн өдрийн хүрээнд эрүүл мэндийн тэгш бус байдлыг бууруулах, арилгах, тусламж, үйлчилгээг хүн бүрт жигд хүргэх зорилгоор “Эрүүл мэндийн тэгш байдлын манлайлагчид” уралдааныг анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн дунд зарлаж байна.

Энэхүү уралдааны зорилго нь: Эрүүл мэндийн тэгш байдлыг Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт болон Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүргэх үйл ажиллагааны гол зарчим, тэргүүлэх чиглэл болгон улмаар нийгмийн болон эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхэнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүнтэй хүртээмжийг бий болгох, нийтийн эрүүл мэнд, нийгмийн сайн сайхан байдалд ашиг тустай шийдвэр гаргах боломжийг олгох үүднээс иргэдийг чадавхжуулахад чиглэсэн тэгш орчныг бүрдүүлэх явдал юм.

Уралдаанд хамгийн сайн санал, шийдлийг боловсруулсан гурван оролцогч ДЭМБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газартай гэрээ байгуулан ажиллах бөгөөд санал болгож буй шийдлүүдийг бодит ажил болгох үүднээс тус бүр 20,000,000 (хорин сая) төгрөгийн гэрээ байгуулах эрхийг авна.

Уралдааны зорилтууд

1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг бодит, нөхцөл байдалд нийцсэн, “үндэслэлтэй” шийдлүүдийг бий болгоход уриалан дуудсан, урам зориг өгч, урамшуулан дэмжихэд чиглэсэн бөгөөд эрүүл мэндийг тодорхойлогч нийгмийн хүчин зүйлс, тухайлбал сэтгэцийн эрүүл мэнд, хотжилт, COVID-19-ийн цар тахал, уур амьсгалын өөрчлөлт, хүйсийн тэгш байдал гэх мэт өргөн хүрээний нийгмийн хүчин зүйлсийг анхааран авч үзэж, эрүүл мэндийн тэгш байдал, хөрөнгө оруулалт, нөөцийн үр ашигтай хуваарилалтад тулгарч буй саад бэрхшээлийг хэрхэн даван туулах талаарх шинэлэг санал санаачилга, үр дүнтэй шийдлийг гаргаж ирэх.



2. Эрүүл мэндийн тэгш бус байдлын үндсэн шалтгааныг арилгах, гол оролцогч талууд түүний дотор эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид болон иргэдийн хариуцлагыг тухайн орон нутгийн түвшинд дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй бодлого, хөтөлбөрийг дэмжих.
3. Нийгмийн болон эрүүл мэндийн тэгш бус байдлыг бууруулахад чухал хувь нэмэр оруулах, эмзэг бүлгийнхэн, ялангуяа шилжин суурьшигчид, хөдөлгөөнт иргэд, “шинээр ядуурлын түвшинд орж ирсэн иргэд” болон хүүхдүүдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг шийдвэрлэхэд онцгой эерэг нөлөө үзүүлэхүйц төслүүдийг дэмжин шалгаруулах явдал юм.

Ажлын хэсэг дараах асуудлуудыг анхаарч сонгон шалгаруулалтыг хийнэ. Үүнд:

- Оролцогч нь дараах үйл ажиллагааны хүрээнд төслийн саналыг ирүүлсэн байна.
- Эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс.
- Бусад салбарын оролцоо, эрүүл мэндийн салбарын дэмжлэг, хамтын ажиллагааны уялдаа холбоо.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад иргэдэд тулгардаг саад бэрхшээл.
- Олон нийт, гэр бүл, хувь хүний оролцоо, санаачилга, тэгш бус байдлын эсрэг дуу хоолой.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар.
- Ажиллагсдынхаа эрүүл мэндийн тэгш байдлыг хэрхэн хангах талаар нийгмийн хариуцлага.
- Иргэдийн эрүүл мэндээ хамгаалах эрх, үүргийн талаарх ойлголт, анхан шатны түвшинд чанартай, үнэ төлбөргүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэрхэн авах талаарх мэдлэг.
- Бусад холбогдох асуудал

Ерөнхий шаардлага

Төсөл нь тэгш бус байдал, эрүүл мэндийн ялгаатай байдлыг бууруулахад чухал эерэг нөлөө үзүүлэх шийдлүүдийг санал болгон хэрэгжүүлэх ба олон нийтийн болон/эсвэл эмзэг бүлгийнхнийг чадавхжуулж, тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдалд ашиг тустай тэгш орчныг бүрдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулахуйц шийдэл гарцууд байна.

Төсөлд тавих нарийвчилсан шаардлага

- Төсөл нь уралдааны сэдэв, агуулгатай бүрэн нийцсэн байх ёстой
- Шийдэл, төсөл хэрэгжүүлэх арга, хүлээгдэж буй үр дүн нь тодорхой, товч хүүрнэх хэлбэрээр байна
- Төслийн бүх үйл ажиллагааг тогтоосон 20,000,000 төгрөгийн төсөвт багтаан хэрэгжүүлнэ
- Төслийг хэрэгжүүлэх хугацаа нь ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай гэрээ байгуулсан өдрөөс хойш 4 сар байна
- “Эрүүл мэндийн тэгш байдлын манлайлагчид” төслийн маягыг бөглөж:
 - PDF хэлбэрээр
 - Заасан хугацаанд
 - Төсөлд оролцох тухай албан хүсэлтийн хамт ирүүлнэ
- Оролцогчид зөвхөн нэг төслийн санал ирүүлнэ

Материал хүлээн авах хугацаа

2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 16.00 цаг хүртэл хүлээн авна.

Материал явуулах хаяг

Дээр дурдсан материалуудыг дараах цахим хаягаар ирүүлнэ үү: tegshbaidal@gmail.com

Сонгон шалгаруулах үйл явц

Сонгон шалгаруулах ажлын хэсэг ажлын 10 хоногт багтаан шалгаруулна. Шалгаруулалтын аргачлал (оноо өгөх аргачлал)-ыг хэлэлцэн ажлын хэсгийн ахлагч баталсан байна.

Төслийн хэрэгжилтийн явцын дэмжлэгт хяналт

Төслийн хэрэгжилтийн явцын дэмжлэгт хяналтыг ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газартай хамтран зохих хуваарийн дагуу ажлын хэсгээс тавих ба үр дүнг хүлээн авч ЭМЯ-ны болон ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газрын цахим хуудсуудаар дамжуулан нийтэд түгээнэ.